



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 17/596

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар баталсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цээл сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинэ суурьшлын бүсэд 15/0.4 кВ-ын чадалтай 160 кВА дэд өртөө угсрах, 15/0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах коммисыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Гишүүд:	М.Мандаххүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	З.Жаргалтуяа	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дэд бүтцийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Ц.Амарсанаа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001944

- 2.
- Б.Лхагва-Очир (Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)
- Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
- Д.Наранбат ("Перфект солишн энд инженеринг" ХХК"-ийн инженер) (зохиогч)
- Д.Ганзориг ("Гегатера тех" ХХК-ийн инженер) (гүйцэтгэгч)
- Нарийн бичгийн дарга: Б.Насанбуян (Цээл сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2.Шугам сүлжээ, дэд өртөөний угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгахыг Цээл сумын Засаг дарга (Д.Буянхишиг)-д, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК (Т.Ганзориг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О. АМГАЛАНБААТАР